



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/186

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам" –ын 4.3.8, 9.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны цонхны засвар ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Н.Нямхүү (Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер)

Д.Бадамбаяр Биеийн тамирын багш

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

М.Мандах (Ерөнхий боловсролын сургуулийн нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт заасан шалгуурыг бүрэн хангасан нөхцөлд хүлээн авч, акт үйлдэн ажлын гүйцэтгэл, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчид бүртгэх шаардпагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Б.Сангицэрэн), өмч хамгаалах байнгын зөвлөлд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

